

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НАЙМДУГААР БҮЛЭГ

8.1 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн жагсаалт

1.Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Д/д	Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1	Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
2	Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
3	Ойгоос мод бэлтгэх эрх	Ойн анги, эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан

2.Соёл, боловсролын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Д/д	Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1	Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

3.Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Д/д	Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1	Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулах	Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар

8.2 дугаар зүйл.Энгийн зөвшөөрлийн жагсаалт

1.Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Д/д	Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1	2	3
1	Газар эзэмших, ашиглах	Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч
2	Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
3	Амьтныг эзэмших, ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

1	2	3
4	Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
5	Ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
6	Хоногт 50 шоометрээс бага ус ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Д/д	Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1	Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч

_____оОо_____